



НИЙСЛЭЛИЙН БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2023 оны 05 сарын 08 өдөр

Дугаар А/90

Улаанбаатар хот


Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Засгийн газрын 2022 оны “Хувийн хэвшил, төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх ажил үйлчилгээний талаар авах зарим арга хэмжээний тухай” 340 дүгээр тогтоол, нийслэлийн Засаг даргын 2023 оны А/243 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах, төр-хувийн хэвшлийн түншлэлийг өргөжүүлэх, бизнесийн үйл ажиллагаанд төрийн оролцоог багасгах зорилгоор төрийн зарим чиг үүрэг, ажил үйлчилгээг хувийн хэвшил, төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх асуудлыг дүүргийн хэмжээнд судалж, санал, дүгнэлт боловсруулах, хэрэгжүүлэх үүрэг бүхий Ажлын хэсгийг хавсралт ёсоор баталсугай.


2.Дүүргийн нутгийн захиргааны болон өмчит байгууллагаас төрийн нэрийн өмнөөс үзүүлж байгаа үйлчилгээнээс хувийн хэвшил, төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх саналыг боловсруулан танилцуулж, хэрэгжүүлэхийг Ажлын хэсэг (Б.Болормаа)-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



А.СҮХБОЛД

Нийслэлийн Багахангай дүүргийн Засаг даргын  
2023 оны 01 дүгээр сарын 08 ны өдрийн  
1790 дугаар захирамжийн хавсралт



## АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

- Дарга: Дүүргийн Засаг даргын Эдийн засаг, нийгмийн хөгжлийн асуудал хариусан орлогч
- Гишүүд: Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Зохион байгуулалтын хэлтсийн дарга (зөвшилцсөнөөр)
- Засаг даргын Тамгын газрын дарга
- Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга
- Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга
- Засаг даргын Тамгын газрын Нийгмийн хөгжлийн хэлтсийн дарга
- Засаг даргын Тамгын газрын Тохижилт, худалдаа үйлчилгээний хэлтсийн дарга
- Нарийн бичгийн дарга: Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн Банкны төлбөр тооцоо хариуцсан ахлах мэргэжилтэн
- Засаг даргын Тамгын газрын Тохижилт, худалдаа үйлчилгээний хэлтсийн Худалдаа үйлчилгээ, үйлдвэрлэл хариуцсан ахлах мэргэжилтэн